

БАТЛАВ ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

П.ДУЛМАА

Төрийн аудитын байгууллагын 2015 оны

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд "Авлигагүй хамт олон" аян зохион байгуулах аяны удирдамж.

Аяны зорилго: Төрийн албанд хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн төлөвлөсөн хүрээнд биш байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулж ажиллах.

Аяны хамрах хүрээ: Төрийн аудитын байгууллагын хэмжээнд /үндэсний аудитын газрын харьяа аймаг нийслэлийн аудитын газрууд/

Аяныг зохион байгуулах хугацаа: Аяныг - 2015-2016 оны 1-р шат

- 2016-2017 онд дараагийн шат гэх

мэт тухай бүр төрлийг өөрчлөн явагдах болно.

Аяны төрөл:

1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилсан байдал /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/
2. Шинэ санаачилага /Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлээ илэрхийлж авлигыг үл тэвчих, ёс зүй, шударга ёсыг эрхэмлэх чиглэлээр хамт олноос санаачилж буй ажил/
3. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм ажиллуулж байгаа байдал /салбар ЭБАТ-ны үйл ажиллагаа/
4. Авлигын эсрэг хууль, тогтоол, дүрэм, журмын хүрээнд мэдлэг сорих тест /байгууллагын нийт ажилтан хамрагдана/

Холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Улсын их хурлын хууль зүйн байнгын хорооны 05 дугаар тогтоолоор батлагдсан дүрэм журам заавар.

Аяны 1 шатны шагнал:

1. I-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал
2. II-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал
3. III-р байр өргөмжлөл мөнгөн шагнал

Аяны удирдамжийн хүрээнд өөрийн байгууллагаас Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлын товч тайлан нотлох баримтын хамт ирүүлэх. /4-5 хуудсанд багтаасан байх/

Жич: 2015 онд Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр өөрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг ирүүлж болно. ЭБАТ-ын ажиллагаатай холбоотой бүртгэл болон бусад материалыг ирүүлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР